Төрийн албаны зөвлөлийн
2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
392 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

[√] Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

[ ] Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Барилга, хот байгуулалтын яам

Нэгжийн нэр:

Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн 340 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулав/

Албан тушаалын нэр:

Төсвийн нэгдсэн төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч /Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн 340 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулав/

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ахлах түшмэл, ТЗ-10

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

15170, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай 3, Засгийн газрын XII байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

## II. АЛБАН ТУШААЛЫН ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Барилга, хот байгуулалтын сайд /ТЕЗ/-ын багцын урсгал болон хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламжийн эх үүсвэр, төсвийг төлөвлөх, боловсруулах, батлуулах, хуваарилах, хэрэгжилтийг хангуулах чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1.Салбарын богино, дунд хугацааны стратеги, үндсэн чиглэлийг баримтлан салбарын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн урсгал болон хөрөнгө оруулалтын жилийн болон дунд хугацааны төсвийн төслийг боловсруулж нэгтгэх, хүргүүлэх, батлуулах;

2.Барилга, хот байгуулалтын сайд /ТЕЗ/-ын багцын батлагдсан, тодотгосон төсвийн хэрэгжилтийг хангах, санхүүжилтийн хуваарийг боловсруулан Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, батлуулах;

3.Сайдын багцын хэмжээнд урсгал болон гадаад, дотоодын эх үүсвэрээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар мэдээлэл, судалгаа гаргах, дүн шинжилгээ хийх замаар холбогдох газар, хэлтэс, харьяа байгууллагуудын үйл ажиллагаатай төсвийн үйл ажиллагааг уялдуулах, удирдлагыг мэдээ, мэдээлэл, арга зүйн зөвлөмжөөр хангах;

4.Сайдын эрхлэх асуудалд хамаарах урсгал зардал, гадаад, дотоодын зээл, тусламж, бусад хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл болон харьяа байгууллагуудын төсвийг батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу хянах, шийдвэрлүүлэх, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

5.Хууль тогтоомжоор олгосон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх -Ш |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1.Барилга, хот байгуулалтын сайд/ТЕЗ/-ын багцын төсвийн хүрээний мэдэгдэл төсвийн хязгаарын саналыг боловсруулан Сангийн яаманд хүргүүлэх; | Салбарын хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангасан байна. | Х, Г |
| | 2.Барилга, хот байгуулалтын Сайд /ТЕЗ/-ын багцын төсвийн төсөл, төсөөлөл, тодотгол, зохицуулалтын саналыг нэгтгэн боловсруулж, холбогдох тооцоо, судалгаа, тайлбар, танилцуулгын хамт Сангийн яаманд хүргүүлэх; | Байгууллагын хэрэгцээ, шаардлагыг хангасан төсөв батлагдсан байна. | Х, Г |
| | 3.Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаар, төсвийн төсөл, төсвийн тодотгол, зохицуулалтын саналыг Засгийн газар, Улсын Их Хурлын байнгын хороо, Улсын Их хурлаар хэлэлцүүлэхтэй холбоотойгоор шаардлагатай мэдээ, мэдээлэл, тооцоо судалгаагаар хангаж ажиллах. | Салбарын хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангасан байна. | Х, Г |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1.Барилга, хот байгуулалтын сайд /ТЕЗ/-ын багцын батлагдсан болон тодотгосон төсвийг эдийн засгийн ангилал, хөтөлбөр, зориулалт, байгууллага, нэгжээр хуваарилан, сар, улирлын санхүүжилтийн хуваарийг боловсруулж, Сангийн сайдаар батлуулах, шаардлагатай нөхцөлд хуваарьт өөрчлөлт оруулах саналыг боловсруулан хүргүүлж, | Хууль эрхийн хүрээнд нийцсэн, хэрэгжилт хангагдсан байна. | Г, Х |

| | | | |
|---|---|---|---|
| | батлуулах, хяналт тавих; | | |
| | 2.Төсвийн тухай хуулиар Улсын төсөв болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах эрх зүйн актыг боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хангах; | Тооцоо, судалгаа, зураг төсөвт үндэслэгдсэн байна. Үнэн зөв тайлагнасан байна. | Г, Х |
| | 3.Төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал боловсруулж батлуулах, тэдгээртэй байгуулах гэрээнд төсвийн холбоотой асуудлаар тусгуулахад дэмжлэг үзүүлэх; | Төсвийн тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | Г, Х |
| | 4.Сайдын багцад ерөнхий нэрээр батлагдсан төсөл, арга хэмжээнүүдийн задаргааг холбогдох газруудтай нэгтгэн боловсруулж, батлуулах; | Төсвийн тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | Г, Х |
| | 5.Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын төсвийг холбогдох байгууллага болон эрх бүхий албан тушаалтнаар батлуулах; | Төсвийн тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | Г, Х |
| | 6.Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, батлагдсан төсөвтэй холбоотой мэдээ, мэдээллээр яамны удирдлага болон Сангийн яам, Үндэсний аудитын газар, бусад байгууллагуудыг хангаж ажиллах; | Төсвийн тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | Г, Х |
| | 7.Барилга, хот байгуулалтын сайд /ТЕЗ/-ын багцын батлагдсан төсөв, төлөвлөгөө, хуваарилалтын мэдээллийг шилэн дансанд хуулийн хугацаанд байршуулах. | Шилэн дансны тухай хууль, Төсвийн тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | Г, Х |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1.Сайдын багцын хэмжээнд урсгал болон гадаад, дотоодын эх үүсвэрээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар нэгдсэн мэдээлэл, судалгаа гаргах, дүн шинжилгээ хийх замаар холбогдох газар, хэлтэс, харьяа байгууллагуудын үйл ажиллагаатай төсвийн үйл ажиллагааг уялдуулах, удирдлагыг мэдээ, мэдээллээр хангах; | Хууль, тогтоомжийн хүрээнд тооцоо судалгаанд үндэслэгдсэн байна. | Г |
| | 2.Харьяа байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийг төсвийн төлөвлөлттэй уялдуулан арга зүйн зөвлөмжөөр хангах; | Хууль, тогтоомжийн хүрээнд тооцоо судалгаанд үндэслэгдсэн байна. | Г |

| | | | |
|---|---|---|---|
| | 3.Хөрөнгө оруулалтын үр дүнг сайжруулахад чиглэсэн хууль эрхийн актыг боловсронгуй болгоход санал санаачлагыг гаргаж, харьяа байгууллагууд болон аймаг орон нутагт зөвлөмж чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулах. | Хууль тогтоомжид нийцсэн байна. Үнэн зөв, бодитоор илэрхийлэгдсэн байна. | Г |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 1.Барилга, хот байгуулалтын салбарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн үйл ажиллагааны зардлын төсвийг хянан боловсруулж, Сангийн яаманд хүргүүлэн батлуулах, хэрэгжилтийг хангах; | Төслүүдийн хэвийн үйл ажиллагаа хангагдсан байна. | Х, Г |
| | 2.Харьяа байгууллагуудын төсвийг батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу хянах, шийдвэрлүүлэх, арга зүйн дэмжлэг үзүүлэх; | Харьяа байгууллагуудын үйл ажиллагаа хангагдсан байна. | Х, Г |
| 5 дугаар зорилтын хүрээнд | 1.Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахих, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах; | Ёс зүйн болон бусад төрлийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлсэн байна. | Г |
| | 2.Албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй боловч цаг үеийн ажлын зайлшгүй шаардлагаар удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэх; | Цаг хугацаандаа шударгаар биелүүлж, гүйцэтгэсэн байна. | Г |
| | 3.Удирдлагыг өөрийн эрхэлсэн асуудлын чиглэлээр шаардлагатай мэдээллээр хангаж, түүний ажилд мэргэжил, арга зүй, техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх. | Мэдээ, мэдээллийн үнэн зөв, шуурхай байдал бүрэн хангагдсан байна. | Г |

## III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

| | | |
|---|---|---|
| Боловсрол | | - Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй. |
| Мэргэжил | | - Эдийн засаг /0311/;<br>- нягтлан бодох бүртгэл, татвар /0411/;<br>- санхүү, банк, даатгал /0412/. |
| Мэргэшил | | - Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх. |
| Туршлага | | - Төрийн албанд 8 жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх |
| Ур чадвар | Дүн шинжилгээ хийх | - судалгааны арга зүй эзэмшсэн байх;<br>- мэдээлэлд тулгуурлан бүтэц чиг үүргийн шинжилгээ хийх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;<br>- байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх;<br>- судалгааны үр дүнг харьцуулан үнэлэх, тайлбарлах;<br>- нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах;<br>- мэдээллийн үнэн, бодит байдлыг шалгах нягтлах;<br>- бусад. |
| | Асуудал шийдвэрлэх | - Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард |

| | | |
|---|---|---|
| | | түмэндээ үйлчлэх;<br>- өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах;<br>- асуудал шийдвэрлэх эдийн засаг, хууль зүйн үндэслэлийг тодорхойлох;<br>- шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах;<br>- хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх мэдлэг, чадвартай байх;<br>- асуудлын шийдэлд шинэлэг байдлыг нэвтрүүлдэг байх;<br>- бусад. |
| | Багаар ажиллах | - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах;<br>- бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох;<br>- ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч байж, бусдыг дэмжих;<br>- шинэлэг санаа, үйлчилгээг нэвтрүүлэх, шинэ санаачилга, бүтээлч үйл хандлагыг нэвтрүүлэх;<br>- хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалт сайтай байх;<br>- бусад. |
| | Бусад | - албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах;<br>- компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн технологи ашиглах;<br>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах;<br>- жендерийн эрх тэгш байдлыг хангах;<br>- авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;<br>- монгол бичгээр уншиж, бичих чадвартай байх. |

**IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ**

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
- Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга

| Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: | Бусад харилцах субъект<br>- Төрийн захиргааны төв байгууллагууд;<br>- Нутгийн захиргааны байгууллага;<br>- Орон нутгийн харьяа газар;<br>- Төрийн бус байгууллагууд;<br>- Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүд;<br>- Иргэн, хуулийн этгээд. |
|---|---|

**V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ**

| Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: |
|---|---|
| Албан тушаал:<br><br>АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ,<br><br>ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА<br><br>..... Д.БАЯРСАЙХАН<br>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br><br>2020 оны 10 дугаар сарын 14-ны өдөр | Байгууллагын нэр:<br><br>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ<br><br>Шийдвэрийн огноо: 20 10 14<br><br>Дугаар: 340 |

МОНГОЛ УЛС ЗӨВШӨӨРӨВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**

Байгууллагын нэр:

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

Шийдвэрийн огноо: .....

Дугаар: .....
(тамга/тэмдэг)

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА ..... С.МАГНАЙСҮРЭН
(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2020 оны 10 дугаар сарын 16 -ны өдөр

МОНГОЛ УЛС
ЗӨВШӨӨРӨӨ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ